



2009 оны 6-р сар

# Шинэ Мэдэц

МОНГОЛ ДАХЬ НУБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН СЭТГҮҮЛ

## НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА - ТАНЫ ТӨЛӨӨ

### Энэ дугаарт:

- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдлийг бууруулах алхам
- Дотоодын шилжих хөдөлгөөний бэрхшээлүүдийг судалгаагаар тодорхойлов
- Хөдөө орон нутгийн өрхийн бага насны хүүхдийн боловсролыг дэмжих нь
- ХДХВ ба ДОХ-ын асуудлаар боловсролын салбарын үнэлгээ хийглээ
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй үндэсний хэмжээний чухал асуудал болоод байна
- Цэвэр ус эрүүл мэндийн баталгаа



## МОНГОЛ ДАХЬ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛАГА

Шинэ Мэдэц сэтгүүлийн энэ удаагийн дугаар нь нийгмийн бүхий л салбар, НҮБ-ын үйл ажиллагаанд харилцан хамааралтай үр дагаврууд дагуулан авчирч буй олон тооны сорилттой дэлхий дахин тулгарч байгаа энэхүү цаг үед хэвлэгдэн гарч байна. Дэлхий дахины өмнө нүүрлэсэн санхүүгийн хямарал, цаг уурын хурцатай өөрчлөлт, доройтож буй хүнсний аюулгүй байдал болон эрүүл мэндийн салбарын олон тооны сорилт зэрэг нь бүх нийтийн сайн сайхан, аюулгүй байдал, хүний эрхийг хангахын төлөө бид бүгдээс шинэ арга барил, шинэ бодлого, шинэ стратеги хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Монгол улсад НҮБ-ын үйл ажиллагаа нь эдийн засаг, байгаль орчин болон нийгмийн салбарын хөгжилд чиглэж байгаа билээ. Дэлхий дахин олон тооны сорилттой тулгарсан энэхүү эгзэгтэй үед бид бүгдийн хамтын хүчин чармайлт эдгээр сорилтын Монгол улсын иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөг сааруулахад чиглэж байгаа болно. Энэ удаагийн дугаарт НҮБ-ын байгууллагууд эдгээр сорилтыг үндэсний болоод тухайн орон нутаг, хамтын нийгэмлэгийн түвшинд Монгол улсын урт хугацааны хөгжил цэцэглэлийн төлөө хэрхэн даван туулан ажиллаж буйг толилуулахыг зорьсон болно.

Хүндэтгэн ёсолсон,

Дебора Комини  
НҮБ-ын Суурин Зохицуулагч

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨӨС ҮҮДЭЛТЭЙ ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ АЛХАМ

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын “Гурван Баян” бүлгийн малчид дэлхийн дулаарлын нөлөөллөөс үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилгоор ширгэсэн бүлгийн эхийг сэргээжээ. 2007 онд гишүүд хамтын хүчээр бүлгийн эхэнд нарс, улиас болон жижиг бут сөөг тарьж малын хөлөөс хашсан байна. Хоёр жилийн дараа бүлгийн эх сэргэж дороос ундрах усны хэмжээ улам бүр нэмэгдэж байгаа ажээ.

“Гурван Баян” малчдын бүлэг нь Онцгой байдлын ерөнхий газар болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах, менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” төслөөс байгуулагдсан нийт 65 малчдын бүлгийн нэг нь юм. Бүлгийн гишүүд уур амьсгалын өөрчлөлттэй олон аргаар тэмцэж талхлагдсан бэлчээрийг ойжуулахад бут сөөг тарьж моджуулан улмаар талбайг хашин нөхөн сэргээлтийг эрчимжүүлж, ой хээрийн түймэртэй тэмцэх зэргээр гамшгийн аюулыг бууруулах ажлуудыг эрчимтэй хэрэгжүүлж байна. НҮБХХ-ийн төсөл нь бүлгийн гишүүдийг сургалтад хамруулж, гамшгийн эрсдлийг бууруулахад чиглэсэн жижиг төслүүдийг санхүүжүүлэх замаар үйл ажиллагааг нь дэмжиж ирсэн юм.

Уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаагаас үүдэн орчны температур эрс нэмэгдэж, цаг агаарын нөхцөл байдал тогтворгүй болж байгааг эрдэмтэд ч төдийгүй дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрөх болсон.

Дэлхийн гадаргын дулаан 1906 оноос хойш сүүлийн 100 жилийн турш 0.74 градусаар нэмэгджээ. НҮБ-ын Уур амьсгал, хүрээлэн буй орчны асуудал хариуцдаг Улс хоорондын ажлын хороо нь дэлхийн дулаарал улам бүр нэмэгдэж XXI зуунд жилийн агаарын температур 1.5-5.1 градусаар нэмэгдэнэ гэсэн урьдчилсан таамаглалыг гаргажээ. Тэдний сэрэмжлүүлж байгаагаар жилийн дундаж агаарын температур гурван градусаар нэмэгдсэн тохиолдолд дэлхийн экосистемд ноцтой хохирол учирч ихэнх биологийн төрөл зүйл мөхөх аюултай юм.

Харин Монгол орны дулаарал дэлхийн дунджаас хурдацтай явагдаж байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. Үндэсний цаг агаар орчны хяналтын хүрээлэнгийн тогтоосноор 1940 оноос хойш жилийн дундаж дулаан 2.1 градусаар нэмэгдсэн бөгөөд энэ үзүүлэлт нь дэлхийн дулаарлын түвшнээс даруй гурав дахин их байна. Энэ нь XXI зуунд 3-5 дахин өсөх хандлагатай байгааг ч эрдэмтэд тооцоолж гаргажээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас манай оронд байгалийн гамшиг ихээхэн нүүрлэж байна. Жишээ нь: 1999-2000, 2000-2001 онд тохиосон зудны улмаас нийт малын 20 орчим хувь хорогдож 10 мянга гаруй малчдын амьжиргаа эрс доройтсон билээ. Үүний улмаас улс орны эдийн засагт учирсан хохирол 413.8 тэрбум төгрөгт (369 сая ам.дол) хүрсэн бөгөөд энэ нь 1991 оноос 2007 оны хооронд Монгол оронд үзүүлсэн албан ёсны тусламжийн 15 хувийг



эээлж байгаа юм. Эрчимтэй явагдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн шороон шуурганы хүч эрс нэмэгдэж байдлыг улам бүр хүндрүүлж байна. 2008 оны тавдугаар сарын 26-27-ны өдрүүдэд Монгол орны зүүн долоон аймгийн 34 суманд болсон гамшигт үзэгдлийн улмаас 52 эрдэнэт хүний амь үрэгдэж, 320 мянган толгой мал хорогдож, нийт 668 цахилгааны шон унажээ. Мөн ийм хэмжээний хүчтэй шороон шуурга 2009 оны дөрөвдүгээр сарын 22-23-ны өдрүүдэд баруун, төв болон говийн аймгуудад тохиолдож нийт найман эрдэнэт хүний амь болон олон толгой мал хорогдоод байна.

Эдгээр байгалийн гамшигт үзэгдлийн улмаас учирч буй хор хохирлын шалтгааныг тодорхойлох зорилгоор НҮБХХ-ийн гамшгийг бууруулах төсөл ихээр хохирол амссан дөрвөн сумдад судалгаа хийсэн юм. Судалгаанаас үзэхэд Цаг уур хүрээлэн буй орчны хяналтын газар болон Онцгой байдлын ерөнхий газар хамтран гамшигт үзэгдэл болох тухай урьдчилан сэргийлэх мэдээллийг тасралтгүй олон нийтийн радио телевизээр дамжуулсан боловч мэдээ зөвхөн сумдын цаг уурын ажилтнууд, засаг дарга нарт л цагтаа хүрсэн байв. Гэвч энэ амин чухал мэдээг цааш нь дамжуулах тогтолцоо байхгүйн улмаас сумаас баг, багаас малчдад хүрч чадаагүй аж. Нөгөөтэйгүүр урьдчилан сэргийлэх мэдээ хүлээн авсан малчид гамшгаас өөрсдийгөө хамгаалах мэдлэг, бэлэн байдал муутай байснаас хохирлоос урьдчилан сэргийлж чадаагүй байна.

Төслийн үндэсний менежер Ш.Болдбаатарын хэлснээр “Судалгаанаас үзэхэд сумын захиргаанд мэдээ дамжуулах боломжгүй тохиолдолд баг руу мэдээ хүргэх тийм механизмыг бий болгож өгөх шаардлагатай байна. Тухайлбал, малчдад гар утас эсвэл радигоор мэдээ дамжуулах механизмыг бүрдүүлж, түүнчлэн гамшигт өртөх магадлалтай газарт шинээр малчдын бүлэг байгуулах хэрэгтэй байна. Байгалийн гамшгийг даван туулахад ганц, хоёр өрх айлаас илүүтэй малчдын нөхөрлөл, хот, саахалт айлуудын хамтарсан үйл ажиллагаа нь илүү үр дүнтэй байдагтай холбоотой.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх ажлыг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх зорилгоор уг төслийн дэмжлэгтэйгээр Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдлийн менежментийн үндэсний стратегийг эрдэмтэн судлаачид, иргэний нийгэм болон бусад хамтрагч талуудын оролцоотойгоор боловсруулсан юм. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдлийг бууруулахын тулд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлсон



энэхүү стратегийн баримт бичгийг 2009 оны дөрөвдүгээр сарын 23-нд зохион байгуулсан үндэсний семинарын үеэр олон талаас нь авч хэлэлцэв. Монгол Улсын Шадар сайд ноён М.Энхболд семинарыг нээж үг хэлэхдээ, уур амьсгалын өөрчлөлт нь манай орны олон иргэд, тухайлбал малчид, тариаланчдын ахуй, амьжиргаанд хүндээр тусч, маш их сөрөг үр дагавартай байгаа учраас үүний эрсдлийг бууруулахад холбогдох бүхий л талуудын хамтын хүчин чармайлт ихээхэн ач холбогдолтой болохыг цохон тэмдэглэсэн юм.

НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч хатагтай Дебора Комини нээлтийн үеэр үг хэлэхдээ нийт гамшгийн 75 хувь нь байгалийн онц аюултай үзэгдлээс гаралтай гэдгийг НҮБ-ын Гамшгийг бууруулах олон улсын стратегийн байгууллагаас тогтоосныг онцлов. Тэрбээр, мөн уур амьсгалын өөрчлөлт нь хүрээлэн буй орчныг доройтуулж, усны хангамжийг бууруулж, хоол хүнсний аюулгүй байдлыг алдагдуулан улмаар айл өрхийн амьжиргааг доройтуулах эрсдэлтэйг ч дурдсан юм. Хатагтай Дебора Комини цааш нь хэлэхдээ “Энэхүү стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг урт удаан хугацааны туршид тогтвортой хэрэгжүүлэхийн тулд холбогдох байгууллагуудын үйл ажиллагааных нь чиглэлд тусгаж өгөх нь онцгой ач холбогдолтой” хэмээн онцолсон билээ.

Оролцогчдын гаргасан зөвлөмжүүдийг стратегийн баримт бичигт болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, бүх холбогдох байгууллага, орон нутгийн иргэдийн мэдлэг, туршлагыг дайчлан олон нийтийн оролцоотойгоор уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдлийг бууруулах арга хэмжээг цаашдаа үндэсний хэмжээнд өрнүүлэх юм.

### ДОТООДЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛҮҮДИЙГ СУДАЛГААГААР ТОДОРХОЙЛОВ

XXI зуунд тодорхойлох олон асуудлуудын нэг нь шилжих хөдөлгөөн юм. Энэ нь улс орон, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн амьдралд эерэг, сөрөг олон үр дагаврыг дагуулж байна. Дэлхий дахинаа эдийн засаг ид уналтад орж байгаа өнөө үед Монгол Улсад хөдөөнөөс хот руу нүүдэллэх, дотоодын шилжилт хөдөлгөөн нь хотын дэд бүтэц, үйлчилгээний ачааллыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлт, орон сууц, ус, ариун цэвэр, бохирдлын асуудлыг шийдэхэд хүндрэл учруулаад зогсохгүй эдгээр учирч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэх үүднээс стратегия шинэчлэн боловсруулах шаардлагатайг сануулж байна.

Монгол Улс дахь дотоодын шилжилт хөдөлгөөний урсгалыг судлах зорилгоор МУИС-ийн Хүн ам зүйн сургалт, судалгааны төв НХХЯ-ны хүсэлтээр, НҮБ-ын ХАС-гийн дэмжлэгтэйгээр дотоодын шилжих хөдөлгөөний дэлгэрэнгүй судалгааг хийлээ. “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар” хэмээх энэ судалгаагаар дотоодын шилжих хөдөлгөөний чиг хандлага, шалтгаан, үр дагаврыг голчлон судалж, манай төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бодлогын зөвлөмж боловсруулах хүрээг тодорхойлов. Уг судалгаа нь мөн 2005 онд УИХ-аар баталсан 2015 он гэхэд хэрэгжүүлэх Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын ядуурлыг бууруулах эхний зорилтын дөрөв дэх зорилгын шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, “Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнөөс үүсч буй сөрөг үр дагаврыг бууруулах”-ыг зорьсон юм.

Судалгаанаас үзэхэд хотод шилжин ирэгсдийн ихэнх нь 15-44 насныхан байна. Тэд ихэвчлэн хот суурин газар бараадан, хөгжилд ойртож, хамаатан саднаасаа дэмжлэг авч, хүүхдүүдээ боловсрол эзэмшүүлэх, мөн ган, зуд зэрэг байгалийн гамшгаас болж амин зуулгаа алдсан, ажилгүйдэл гэх мэт эдийн засгийн шалтгааны улмаас хот суурин руу шилждэг аж.

Хот руу нүүдэллэх хүмүүсийн урсгал цаашид ч үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд орон нутгийн зүгээс иргэдийнхээ хэрэгцээнд анхаарч, хэрэгцээг нь хангах явдлыг сайжруулж, шилжилт хөдөлгөөнийг бууруулахын тулд орон нутгаа хөгжүүлэх шаардлагатай байна. Мөн орон нутгийн эрх мэдлийн төвлөрлийг сааруулж, бие даан хөгжиж, орон нутгийн хөгжлийн стратегия хэрэгжүүлэх эрх мэдлийг орон нутгийн засаг захиргаанд түлхүү олгохын зэрэгцээ хотод шилжиж ирсэн иргэдэд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй болгох шаардлагатай байгаа юм.

Судалгааг 2009 оны дөрөвдүгээр сарын 7-нд олон нийтэд танилцуулсан бөгөөд одоо уг судалгааны үр дүнг холбогдох байгууллагууд хэлэлцэж байна. Энэхүү судалгаа нь цаашид хот, хөдөөгийн төлөвлөлтийн чиглэлээр ажилладаг бодлого боловсруулагчид, судлаачдад төдийгүй шилжилт хөдөлгөөн, хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд дараа дараагийн хяналт үнэлгээг хийхэд чухал лавлагааны хэрэгсэл болох юм.

## ХДХВ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ ХИЛИЙН ДАГУУХ БҮС НУТГУУДАД



*Төслийн танилцуулах уулзалт*

Хэдийгээр Монгол Улс одоогоор ХДХВ-ийн тархалт багатай орон гэгдэж байгаа ч, Хятад, ОХУ зэрэг ХДХВ-ийн тархалт өндөр орнуудтай хил залгаа оршдог эрсдэл ихтэй орнуудын нэг юм. Хилийн дагуух бүс нутагт албан болоод албан бус худалдаа арилжаа, эдийн засаг өсөхийн хэрээр биеэ үнэлэх явдал ч газар авч, цаашид ХДХВ тархах боломжийг бүрдүүлж байна.

ХДХВ-ийн халдвар авч, бусдад халдаах хамгийн эрсдэл ихтэй хүмүүс бол хилээр нэвтэрч, хилийн ойролцоо цугладаг ганзагын наймаачид, жолооч нар юм. Монгол Хятадын хилийн боомтууд нь хоёр орны иргэд ажил эрхлэх, худалдаа наймаа хийх зорилгоор цугладаг хамгийн анхаарал татахуйц бүс бөгөөд эдгээрээс жилд дунджаар 130 000 хүн хил нэвтэрдэг Дорноговь аймгийн Замын-Үүд боомт болон 60 000 хүн нэвтэрдэг Ховд аймгийн Булган сум нь хамгийн хөл хөдөлгөөнтөйд тооцогдож байна.



*Хилийн боомтод ХДХВ-ээс сэргийлэх төслийн үе тэнгийн сургагч багш нарын сургалт*

Хятад, Монгол Улсад Люксембургийн санхүүжилттэй төсөл хэрэгжиж, төслийн үйл ажиллагааг тус хоёр орны НҮБ-ын ХАС болон Улаан загалмай нийгэмлэгээр дамжуулан, орон нутгийн эрх баригчидтай хамтран зохицуулж байна. Төслийн үйл ажиллагаанд ХДХВ, БЗДХ-наас сэргийлэх талаар биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн дунд үе тэнгийнхэн сургалт зохион байгуулах, бэлгэвчийн хэрэглээг сурталчлах, хөдөлгөөнт хүн амын мэдлэгийг нэмэгдүүлэх, ухуулга, нөлөөлөл, нийтэд хүрсэн үйл ажиллагаа явуулах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор сургалт, зохицуулалтын үйл ажиллагаа багтаж байна.



*Ховд аймгийн Булган сумын хилийн боомтын байдал*

Тус хоёр сумын төвд сайн дурын зөвлөгөө, шинжилгээний үйлчилгээг нэвтрүүлж, хүмүүсийн нэр, хаягийн тодорхойлолтгүйгээр шинжилгээ авч, ХДХВ, БЗДХ-ын талаар мэдээлэл авах боломжийг хангаж, нутгийн болоод хөдөлгөөнтэй хүн амын дунд уг үйлчилгээг сурталчилж байна.

## ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ НҮЭМ-ИЙН ЭМ ХЭРЭГСЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТОГТВОРТОЙ ХАНГАМЖИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭНЭ

НҮЭМ-ийн эм хэрэгслийн тогтвортой хангамж нь эх хүүхдийн эндэгдлийг бууруулж, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын тархалтыг багасгах зорилго бүхий МХЗ-д хүрэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлдэг.

Одоогоор Монгол Улсад эх, нярайн эндэгдэл хөдөө орон нутагт харьцангуй өндөр байгаа бөгөөд өнгөрсөн арван жилд БЗДХ-ын тархалт гурав дахин нэмэгдэж, ХДХВ/ДОХ-той хүний тоо сүүлийн гурван жилд 67 хувиар өсөв.

НҮЭМ-ийн эм хэрэгслийн тогтвортой хангамжийг бүрдүүлэхийн тулд Жирэмслэхээс Сэргийлэх Эм Хэрэгслийн болон НҮЭМ-ийн бусад эм хэрэгслүүд түүний дотор эх барих, нярайн яаралтай тусламж, БЗДХ, ХДХВ-ийн шинжилгээнд шаардлагатай эм хэрэгслийг бүх нийтэд хүртээмжтэй болгон, НҮЭМ-ийн эм хэрэгслийн тогтвортой хангамжийг дэмжиж төрөөс зохих ёсоор санхүүжүүлэн, эрүүл мэндийн үйлчилгээний үр дүнтэй дэд бүтцийг бий болгох нь чухал юм.

НҮЭМ-ийн эм хэрэгслийн тогтвортой хангамжийн салбарт тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд НҮБ-ын Хүн Амын Сангийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн

яамны боловсруулсан “НҮЭМ-ийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн үндэсний стратеги”-ийг Монгол Улсын Засгийн газар 2009 оны дөрөвдүгээр сард баталсан.

НҮЭМ-ийн эм хэрэгслийн тогтвортой хангамжийг сайжруулж, хангамжийн удирдлага, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх төрийн болоод хувийн хэвшлийн түншлэлийг дэмжин, чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг дэс дараатай НҮБ-ын Хүн Амын Сантай хамтран хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улс 2009 оны улсын төсөвт НҮЭМ-ийн эм хэрэгсэл, нэн ялангуяа ЖСЭХ худалдан авахад зориулж 85 сая төгрөг хуваарилав.

НҮЭМ-ийн эм хэрэгслийн тогтвортой хангамжийн талаар Засгийн газраас зорилт тавин ажиллаж, улмаар НҮЭМ-ийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийг боловсронгуй болгох НҮБ-ын Хүн Амын Сангийн дэлхийн хөтөлбөрөөс санхүүжилт авах есөн орны нэгээр Монгол Улс сонгогдоод байна. Дэлхийн эдийн засгийн хямрал болоод Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй байгаа энэ үед уг хөтөлбөр нь үндэсний стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр

“НҮЭМ-ийн эм хэрэгслийн хэрэгцээг хангах нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн НҮЭМ-ийг хамгаалах замаар тэдний амь насыг аврах дэлхийн хүчин чармайлтын гол үндсэн суурь юм.”

— НҮБ-ын ХАС-ийн Гүйцэтгэх захирал Торая Ахтед Обайд



*Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн асуудлаарх дээд хэмжээний уулзалт, 2008 оны 11-р сарын 27*

**ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ӨРХИЙН БАГА НАСНЫ  
ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ НЬ**



*Ой дөрвөн сартай хүүгээ тэврэн зогсож буй Увс аймгийн Наранбулаг сумын иргэн ©Намуун Зэт студи 2009*

Алслагдсан хөдөө орон нутгийн малчин өрхийн бага насны хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах нь Монголын боловсролын салбарын тулгамдсан асуудлуудын нэг төдийгүй НҮБ-ын Хүүхдийн Сангийн хувьд ч анхаарч ажиллах асуудал юм. Монголын нийт хүн амын 40 хувь нь хөдөө орон нутагт амьдардаг билээ. Харин хөдөөгийн айл өрхийн 2-6 насны хүүхэд багачуудын дөнгөж 42 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна.

Хүүхэд багачуудыг зургаан настайгаас нь боловсролын зохих үйлчилгээнд хамруулах нь дараа, дараачийн шатны сургалтад амжилт гаргах нөхцөл бололцоог бүрдүүлдэг нь судалгаагаар нотлогдсон байдаг. Тиймээс Монгол Улс 2015 он гэхэд Мянганы Хөгжлийн үндэсний зорилтод заасанчлан хүүхдүүдийг бага боловсролд бүрэн хамруулахын тулд алслагдсан орон нутгийн хүүхэд багачуудад сургуулийн өмнөх чанартай боловсрол эзэмшүүлэхэд анхаарч ажиллах явдал чухлаар тавигдаж байгаа юм.

НҮБ-ын Хүүхдийн Сан төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран бага насны хүүхдийн хөгжил ялангуяа алслагдсан орон нутгийн хүүхэд багачуудад энэ төрлийн үйлчилгээг хүргэх асуудалд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Төрөхийн өмнөх үеэс эхлээд гурван нас хүртэлх хугацаа нь хүүхдийн оюун ухаан, нийгэм-сэтгэл зүйн хамгийн хурдацтай хөгжих тулгуур үе шат байдаг. Энэ хугацаанд хүүхэд багачуудыг хүчирхийлээс хамгаалах, эрүүл мэнд, хоол тэжээлийг анхаарах, өөрийгөө илэрхийлэх боломж бололцоог нээхэд нь эцэг, эх, асран хүмүүжүүлэгчдийн үүрэг чухал байдаг.

Монгол Улсын хүн амын 23 орчим хувийг 0-6 насны хүүхэд багачууд бүрдүүлдэг. Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд 2015 он хүртэлх хугацаанд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах түвшинг 99 хувьд хүргэх зорилго дэвшүүлсэн билээ. Тийм хэдий ч өнөөгийн байдлаар сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй байдал нь дөнгөж 57 хувьтай байгаа юм. Мөн цэцэрлэгт хамрагдах байдал 44 хувь байгаа бол хувилбарт сургалтад хамрагдах байдал 13 хувьтай байна.

Энэ нь уг зорилгод хүрэхийн тулд өнөөгийн нөхцөлд холбогдох бүхий л талуудын зүгээс асар их хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлагатайг илтгэж байна.

Сүүлийн 20 жилд Монгол оронд хүүхдийн цэцэрлэгүүдийн даац хязгаарлагдмал, дэд бүтцийн хөгжил хангалтгүй, нүүдлийн амьдралын хэв маяг зэрэг нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдахад сөргөөр нөлөөлж байгаа гол хүчин зүйл байсаар иржээ. Ихэнх аймгуудад сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүчин чадал шаардлагатай хэмжээнд хүрдэггүй тул сургуулийн өмнөх насны бүх хүүхэд багачуудыг цэцэрлэгт хамруулах боломжгүй байдаг. Эл хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан үзээд 2008 онд НҮБ-ын Хүүхдийн Сан, БСШУЯ-тай хамтран боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах зорилгоор алслагдсан 21 суманд 38 нүүдлийн гэр цэцэрлэг байгуулахад тусламж үзүүлсэн юм.

2008 оноос БСШУЯ-наас алслагдсан аймаг орон нутгийн явуулын цэцэрлэгт ажиллах багш нарыг бэлтгэх сургалт явуулж, сургалтын чанарыг сайжруулах, сургалтын гарын авлагаар



**Явуулын гэр цэцэрлэг(хүлээлгэн өгөх ёслолын үеэр) 2008 он ©Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан/0002EDU-2.5-0001/S Nansal**

хангах ажлыг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан байна. Айл өрхөөр явж бага насны хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлдэг явуулын багш нарын тусламжтайгаар 2008 онд 3-6 насны 1920 эмзэг бүлгийн хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшжээ. Гэр оронтой нь ойр байдаг утгаараа гэр цэцэрлэгүүд болон явуулын багш нар эцэг, эхчүүдтэй илүү ойр харьцах боломжтой байдаг бөгөөд ингэснээрээ тэд бага насны хүүхдийн хөгжлийн талаарх гол мэдээлэл, мэдлэгийг эцэг эхчүүдэд хүргэж чаддаг билээ.

Сургуулийн өмнөх албан боловсролын гадна орхигдсоор ирсэн алслагдсан хөдөө орон нутгийн хүүхэд багачуудад сургуулийн өмнөх боловсрол олгоход гэр цэцэрлэгүүд болон явуулын багш нар онцгой үүрэг гүйцэтгэдэг. Харамсалтай нь ийм үйлчилгээний хамрах цар хүрээ хязгаарлагдмал хэвээр байна. Тиймээс өнөөгийн эдийн засгийн хямралын болзошгүй сөрөг нөлөөнөөс сэргийлж, гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжин, тэднийг сургуульд бэлтгэхэд эцэг эхчүүд, асран хүмүүжүүлэгчдийн чадварыг сайжруулах шаардлага зайлшгүй тавигдаж байна. Зургаа хүртэлх насны хүүхэд багачуудын сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй байдал нь хангалтгүй байгаа энэ нөхцөлд тэдний боловсрол, хөгжлийг эрчимжүүлэхэд эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлага улам чухал болж байна.

Гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжиж тэднийг сургуульд бэлтгэхэд эцэг, эхчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр НҮБ-ын Хүүхдийн Сангаас БСШУЯ, орон нутгийн засаг захиргаа болон бусад холбогдох байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.

Тухайлбал, 2008 онд Ховд, Баян-Өлгий, Дорнод, Увс аймгууд болон Улаанбаатар хотод бага насны хүүхдийнхээ хөгжлийг дэмжих тухайд эцэг, эхчүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цуврал сургалтыг НҮБ-ын Хүүхдийн Сангийн техникийн болон санхүүгийн тусламжтайгаар зохион байгуулсан юм.

2009 онд “Гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага” цуврал видео зөвлөмжийн эхний гурван хэсгийг Намуун Зэт студид бэлтгэж зарим алслагдсан сум, баг, дүүрэг, хороодын эцэг эхчүүдэд хүргээд байна.

“Гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих энэхүү гарын авлагын зорилго нь эцэг, эх, асран хүмүүжүүлэгчдэд хүүхдийнх нь хөгжлийн талаар мэдээлэл өгөх, туршлага эзэмшүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх уламжлалт арга барил, итгэл үнэмшлийг орчин үеийн арга барилтай хэрхэн хослуулах, хүүхдийн насны онцлогт тохирсон үйл ажиллагаагаар дамжуулан тэдний сурах идэвх санаачилгыг нь хөхиүлэн дэмжихэд оршино” хэмээн Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн суурин төлөөлөгч доктор Бэртрон Дэймүүлан онцлон тэмдэглэсэн юм.

Мөн цуврал видео зөвлөмжийг алслагдсан хөдөө орон нутгийн эцэг эхчүүдийн хэрэгцээнд зориулан гаргасан билээ. Энэ нь хүүхдийг төрөхөөс нь эхлээд сургуульд орох нас хүртэл нь

ХЭЛ	МОНГОЛ (2.1 Stereo Surround)	ҮН	1080i
ХАТГАЛ	120 минут	СЭТ	1080i
ХӨД	1080i/720p/480p/480i	СЭТ	1080i

UNICEF UN WOMEN

**Гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага**

хэрхэн асарч, бас хөгжүүлэх цогц мэдээллүүдийг багтаасан. Хөдөөгийн малчид нүүдлийн мал аж ахуй эрхлэн цаг наргүй ажилладаг учраас үр хүүхдэдээ төдийлөн цаг зав гаргаж чаддаггүй. Тиймээс тэдний эрэлт, хүсэлтэд үндэслэн хөдөө

**Ховд аймгийн Жаргалан сумын иргэний яриа:** “Хүүхдийг хэрхэн хүмүүжүүлэх, хүүхдэд ер нь юу шаардлагатай байдаг, тэдэнд цаг зав гаргахын ач холбогдол юунд байдаг талаар маш их зүйл мэдэж авлаа”.

орон нутгийн эцэг, эхчүүдэд суурь мэдээлэл өгөх зориулалттай видео зөвлөмжийг видео тоглуулагч болон телевиз ашиглан гэртээ үзэх боломжтой байхаар бэлтгэсэн.

Гарын авлагын 1-3 дугаар хэсэгт гурав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн асуудалд голлон анхаарч, хоол тэжээлийн

дутагдал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мөн шүдийг зөв арчлах зөвлөгөө, вакцинжуулалт, хүүхдийн өсөлт хөгжлийн талаарх мэдээлэл зөвлөмжүүдийг оруулсан байна.

Дараачийн цувралаар гэр бүлд 4-6 настай хүүхдийн хөгжлийг хэрхэн дэмжиж, тэднийг сургуульд хэрхэн бэлтгэх талаар эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх юм.

**Увс аймгийн Наранбулаг сумын иргэний яриа:**

“Би гурван сартай охинтой. Хүүхдийг ямар орчинд ямар тоглоомоор тоглуулж, хөгжүүлэх талаар мэдэж авлаа. Одоо авч байгаа энэ гарын авлагаа хойшдоо үзээд илүү ихийг мэдэж авах байх гэж бодож байна. Шүд арчлах тухай хичээл маш их таалагдлаа. Цувралын дараачийн хэсгүүдийг хийх гэж байгаад маш их баяртай байна. Ялангуяа алслагдсан хөдөө орон нутгийн эцэг эхчүүдэд их тустай зүйл болно гэдэгт итгэлтэй байна”.

**Увс аймгийн Наранбулаг сумын иргэний яриа:**

“Видео хичээл үнэхээр их таалагдлаа. 8-9 насны хүүхдүүдтэй эцэг эхчүүдэд зориулсан тусгай цуврал гаргавал маш их хэрэгтэй гэж бодож байна. Өсвөр насны хүүхдүүд маш их эмзэг байдгаас гадна онцгой халамж, анхаарал шаарддаг. Энэхүү цуврал зөвлөмжийг эцэг эхчүүдэд зориулсан боловсролын цогц хэрэгслийн эхнийх нь боллоо гэж бодож байна.”





## НҮБ-ЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН, СОЁЛЫН БАЙГУУЛЛАГА

### ХДХВ БА ДОХ-ЫН АСУУДЛААР БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮНЭЛГЭЭ ХИЙГДЛЭЭ

Монгол улс ХДХВ-ийн халдварын төвшин 0.1 хувиас бага учраас тархалт багатай орны тоонд орсон хэвээр байгаа. Гэсэн хэдий ч халдварын эсрэг авах хариу арга хэмжээнд боловсролын салбарын тулгамдсан асуудлууд байсаар байна.

НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд “ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлэх талаарх Монголын боловсролын салбарын бодлогын арга хэмжээ, бэлэн байдал” тойм салбарын судалгаа Бээжин дэх ЮНЕСКО-



*ХДХВ ба ДОХ-ын асуудлаар Боловсролын салбарын  
Үнэлгээний тайлан оролцогч талуудын Форум дээр  
хэлэлцэгдлээ.*

гийн суурин төлөөлөгчийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийгдлээ. Тус үнэлгээг Монголын Нээлттэй Нийгэм Форум гүйцэтгэж, ХДХВ ба ДОХ-ын асуудлыг албан боловсролын эрүүл мэндийн хөтөлбөрт бэлгийн боловсролын нэг хэсэг болон тусгасан зэрэг боловсролын салбарын хүрсэн олон ололт амжилтын зэрэгцээ ХДХВ ба ДОХ-ын талаар баримтлах төлөвлөлт/хяналт үнэлгээний шалгуур байхгүй, эрүүл мэндийн мэргэшсэн багш дутагдалтай, багш бэлтгэх үйл ажиллагааны цогц төлөвлөгөө, түүнд зарцуулах төсөв тодорхойгүй зэрэг бэрхшээл, шийдвэрлэх олон асуудал байгааг тодруулан гаргасан байна.

Тус судалгааны тайланд ХДХВ ба ДОХ-ын асуудлаар Боловсролын салбарын баримтлах стратегийг боловсруулахдаа түүнийг хэрэгжүүлэх

үйл ажиллагааны төлөвлөгөө болон зарцуулах зардлыг тодорхой тусгах шаардлагатай гэдгийг онцолжээ.

Энэхүү судалгааны тайланг хэлэлцэх зорилгоор 2009 оны 3 дугаар сарын 31-нд Улаанбаатар хотноо зохион байгуулсан оролцогч талуудын Форумын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцлоо.

Тус Форумын нээлт дээр Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны дэд сайд хатагтай Ч.Куланда хэлсэн үгэндээ боловсролын салбарын бүх төвшиндөө ХДХВ ба ДОХ-оос сэргийлэх стратеги боловсруулах, боловсрол олгоход илүү анхаарах хэрэгтэй гэдгийг онцоллоо.

ХДХВ ба ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хорооны дарга хатагтай Т.Хадхүү тавьсан илтгэлдээ үндэсний хэмжээнд баримталж буй бодлого, стратегийн чиглэл, үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, ДОХ-той тэмцэх үндэсний стратегийн төлөвлөгөө, гурван нэгийн зарчмын зарчмыг хэрэгжүүлэхэд үндэсний, олон улсын, төрийн, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа чухал байгаа гэдгийг онцоллоо. Үндэсний хорооны үйл ажиллагаа манлайлал, хамтын ажиллагаа, ХДХВ-ын халдвартай амьдарч буй хүмүүсийн оролцоо, нотолгоонд суурилсан арга хэмжээ, таатай орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллах болохоо танилцууллаа.

Түүнчлэн оролцогчдод ХДХВ ба ДОХ-ын асуудлаар ЮНЕСКО-гийн баримтлах зорилго, үйл ажиллагааны хүрээг танилцуулж, EDUCAIDS гарын авлагыг тараасан нь тэдэнд Боловсролын салбарын хувьд ХДХВ ба ДОХ-ын асуудал салшгүй нэгэн хэсэг болж байгаа гэдгийг ойлгоход туслах болно гэж үзлээ.

ЮНЕСКО цаашид Боловсролын салбарын баримтлах стратегийн төслийг сайжруулах, үйл ажиллагааны төсөв тооцсон төлөвлөгөө боловсруулах ажлыг үргэлжлүүлэн дэмжих болно.

## СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ МОНГОЛ УЛСАД ХӨГЖҮҮЛЭХ, ПРАКТИК ТҮВШНИЙ ЧАДАВХИ БИЙ БОЛГОХ

ЮНЕСКО-гийн санаачилгаар Монгол үндэстний соёлын илэрхийлэл болдог төрөл бүрийн бүтээлүүдийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соёлын өвийг дижитал хэлбэрт оруулан үлдээх зорилго бүхий энэхүү төсөл 2008 оны дөрөвдүгээр сараас эхлэн БНСУ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилттэйгээр хэрэгжиж эхэлсэн. Төсөл Соёлын Илэрхийллийн Олон Төрөлт Бүтээлийг Хамгаалах болон Хөхиүлэн Дэмжих Олон Улсын Конвенцид суурилсан бөгөөд соёлын илэрхийллийн олон янз байдлын үнэ цэнийг ойлгуулах болон тухайн улсын соёлын бодлоготой уялдуулах зорилготой аж.

Төслийн үйл ажиллагаа улс орны соёлын болон бүтээлийн үйлдвэрлэлийн олон талт байдал дэмжлэг үзүүлэх, улмаар соёлын өвийг дижитал хэлбэрт оруулах гол зорилготой юм. ЮНЕСКО-гоос техникийн ихээхэн өндөр шаардлагатай уг төслийн үйл ажиллагааны төслийн баг, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Хороо болон Урлагийн ажилтны холбооны гишүүдэд техникийн туслалцаа болон зөвлөх үйлчилгээгээр хангах ажлын гүйцэтгэгчээр БНСУ-ын “КОС-СА”-г сонгожээ. Тус байгууллага нь соёлын өвийг дижитал хэлбэрт оруулах тал дээр арвин туршлага хуримтлуулсан байгууллага юм.



*Монголын төслийн баг олон төрлийн соёлын болон бүтээлийн үйлдвэрлэл танилцуулж байгаа нь*

Уг төслийн албан ёсны нээлтийн дараа ЮНЕСКО-гийн урилгаар Хонконгийн олон улсын зөвлөх ноён Десмонд Хуй Монголд ирж, төслийн багийн гишүүдэд төслийн нөхцөл байдлын судалгаа хийх аргачлал болон үндсэн ойлголтын талаар мэдээлэх, хамтран ажиллах байгууллагыг сонгох, Монгол орны соёлын болон бүтээлийн үйлдвэрлэлийн чадамжид хэрхэн үнэлгээ өгөх талаар зөвлөж, мөн оюуны өмчийн эрхийн холбогдох асуудлыг судлах зарим ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

### Соёлын агуулга гэж юу вэ?

“Соёлын агуулга” гэдэг нь соёлын өвөрмөц байдлыг илэрхийлсэн эсвэл түүнээс эх үүсвэр бүхий урлаг, соёлын бүтээлийн хэм хэмжээг илэрхийлсэн бэлэгдлийн ойлголт юм.

*(Соёлын Илэрхийллийн Олон Төрөлт Бүтээлийг Хамгаалах болон Хөхиүлэн Дэмжих Олон Улсын Конвенци, Зүйл 4.2, 2005 оны 10 дугаар сар)*

Ноён Десмонд Хуйгийн зөвлөмжийн дагуу төслийн баг соёлын болон бүтээлийн үйлдвэрлэлийн салбарыг судлахдаа дараахь дөрвөн бүлэгт ангилах шийдэлд хүрсэн байна. Үүнд:

- Уран зураг, гар урлал, загвар болон хэвлэл
- Урлагийн тоглолт, кино, радио, ТВ болон сурталчилгаа
- Загвар, уран барилга, тоглоом болон хөдөлгөөнт дүрс
- Музей, өв, аялал жуулчлал ба чөлөөт цагт зориулсан арга хэмжээ гэсэн ангиллууд багтаж байгаа юм.

Энэхүү судалгааг 2009 оны эхээр дуусган, Монгол Улсын соёлын болон бүтээлийн үйлдвэрлэлийн судалгааны дүнг хэлэлцэх, соёлын өвийг дижитал хэлбэрт оруулах төслийн зорилт тодорхойлох уулзалтыг 2009 оны дөрөвдүгээр сарын 7-8-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо

### Соёлын илэрхийллийн олон янз байдлын бүтээлч үйлдвэрлэл

Соёлын илэрхийллийн олон янз байдлын бүтээлч үйлдвэрлэл гэдэг нь “соёлын бүтээл болон үйлчилгээг үйлдвэрлэн, түгээн дэлгэрүүлэх үйлдвэрлэл” болно. Үүнд:

- Соёлын өв, гар урлал, дуу хөгжим, хэвлэл, кино, загварын салбарын соёлын бүтээл болон биет
- Уран барилга, аялал жуулчлал, урлагийн тоглолт, сурталчилгаа

Бүтээлч үйлдвэрлэлийг бие даасан салбар болгох гол онцлог шинж нь оюуны өмчийн менежмент ба ашиглалт, түүнчлэн бүтээлч, шинэ санаачлага, ур чадварын үнэлж баршгүй хувь нэмрээр тодорхойлогддог байна.

1. Соёлын Илэрхийллийн Олон Төрөлт Бүтээлийг Хамгаалах болон Хөхиүлэн Дэмжих Олон Улсын Конвенци, Зүйл 4,5, 2005 оны 10 дугаар сар
2. Гонконгийн Бүтээлч Үйлдвэрлэлд хийсэн нөхцөл байдлын судалгаа, Desmond Hui, Гонконг: 2003 он, 13 хуудас

зохион байгуулсан байна. Угуулзалтад ЮНЕСКО, КОССА болон төслийн багийн гишүүд оролцож судалгааны дүнг сонссон бөгөөд соёлын өвийг дижитал хэлбэрт хэрхэн оруулах талаар санал бодлоо солилцсон.

Харин ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Хороо ЮНЕСКО-гийн Бээжин дэх газар, КОССА-тай хамтран Монголын мэргэжилтнүүдийг соёлын бүтээлийг дижитал болгох үйл ажиллагаанд сургах сургалт-семинарыг 2009 оны тавдугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулах юм.

Төслийн ач холбогдол нь Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөлд соёлын болон бүтээлийн үйлдвэрлэлийн ашигтай, давуу талуудын тухай ойлголт, мэдээллээр нийт хүн ам, холбогдох байгууллага, хамтран ажиллах



*Зорилт тодорхойлох уулзалтын төлөөлөгчид  
2009 оны 04 сар*

байгууллага болон шийдвэр гаргагч нарыг хангаж байгаад оршиж байна гэж үзэж болно. Төсөл 2010 оны эхээр дуусах юм.



## ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА

### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ЧУХАЛ АСУУДАЛ БОЛООД БАЙНА



Зохистой хөдөлмөрийг хөхиүлэн дэмжинэ гэдэг нь аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, нөхцөлийг бий болгохтой шууд холбоотой. Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас Монгол Улсад авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга хэмжээний нэлээд хувь нь энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Байгуулагдсанаасаа хойш өнгөрсөн 90 жилийн хугацаанд Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь нийгмийн гурван талт түншлэл болох Засгийн

газар, ажил олгогч болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудад ажлын байранд гарсан осол, эрсдлийг бууруулах зорилтын хүрээнд чадавхийг бэхжүүлэх, олон улсын туршлага хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөр, аргачлал боловсруулах чиглэлээр ажиллаж байна.

ОУХБ-аас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155 дугаар конвенци, 164 дөрөвдүгээр зөвлөмжийг гаргасан бөгөөд Монгол Улс уг конвенцид 1998 оны хоёрдугаар сарын 3-нд нэгдэн оржээ. Үндэсний хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОУХБ 2004 оноос эхлэн техникийн туслалцаа үзүүлж эхэлсэн юм. Харин Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бие даасан Монгол Улсын хуулийг 2008 оны тавдугаар сарын 22-нд УИХ-аар батлан гаргажээ.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг хангах нь манай орны хувьд чухал асуудлуудын нэг хэвээр байна. Улсын мэргэжлийн хяналтын газрын 2008 оны тайланд нийт 16961 аж ахуйн нэгж байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт шалгалтад

“Эдийн засгийн хямралын энэ үед аливаа бодлого стратегийг хэрэгжүүлэхдээ ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг орхигдуулахгүй байхыг бид байнга анхаарах ёстой... Аюултай нөхцөл бол хөдөлмөрийн гунигт түүхийн эхлэл. Энэхүү гунигт түүхийг жил бүр хэдэн сая хүн давтаж байгаа боловч ихэнх тохиолдолд тэдний нэр харагдахгүй, үзэгдэхгүй байдлаар чимээгүйхэн өнгөрч байна. Гэтэл энэхүү гунигт байдлаас урьдчилан сэргийлэх боломж байсаар байна.”

*ОУХБ-ын Ерөнхий захирал Хуан Сомавиагийн Дэлхийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр хийсэн мэдэгдлээс*

хамрагдсаны 14.8 хувь нь хангалттай сайн, 68.6 хувь нь хангалттай, 16.9 хувь нь хангалтгүй гэсэн үнэлэмж авсныг дурджээ.

Түүнчлэн, үйлдвэрлэлийн осол гол төлөв уул уурхай, барилгын салбарт гарч байгаа бөгөөд удаад нь эрчим хүч, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбаруудыг нэрлэж байна. 2008 оны байдлаар нийт 480 аваар осол бүртгэгдэж, 656 хүн гэмтэл бэртэл авснаас 162 хүн нас барсан бөгөөд тэдний ар гэрт ойролцоогоор 589 сая төгрөгийн нөхөн олговор олгожээ.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулахын тулд Монгол Улсын Засгийн газар ОУХБ-тай хамтран 2009 оны дөрөвдүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Азийн зарим орнууд оролцсон “Уул уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах” тухай бүсийн семинарыг зохион байгууллаа.

Уг семинарын төгсгөлд Монгол, БНХАУ, Энэтхэг, Индонез, Малайз, Филиппин, Вьетнам улсаас ирсэн төлөөлөгчид ОУХБ-ын бусад

гишүүн орнуудад хандан Уул уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1995 оны 176 дугаар конвенцид нэгдэн орж, хэрэгжүүлэх асуудлыг нухацтай авч үзэх, энэхүү зорилгод хүрэхэд шаардагдах алхмуудыг авч хэрэгжүүлэхийг уриалсан бөгөөд ОУХБ-ын зүгээс өөрийн гишүүн орнууддаа 176 дугаар конвенц болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бусад холбогдох конвенциудад нэгдэн орох, практик хэрэгжилтийг нь хангах, улмаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад нь үргэлжлүүлэн туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хүсэв.

Дэлхийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдрийг жил бүрийн дөрөвдүгээр сарын 28-нд тэмдэглэдэг билээ. Энэхүү өдөр Үйлдвэрчний эвлэлийн байгууллага, НХХЯ, Монголын Ажил олгогч эздийн холбоотой хамтран хэвлэлийн бага хурал зохион байгуулж, ажлын байрны нөхцөлөөс шалтгаалан гарч буй осол аваар, мэргэжлийн өвчний тохиолдлыг бууруулахад нийгмийн түншлэлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцох байдал чухал үүрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэсэн юм.



## ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

### ЦЭВЭР УС ЭРҮҮЛ МЭНДИЙН БАТАЛГАА

Ус, эрүүл ахуй, ариун цэврийн байдлыг сайжруулах нь Монгол Улсад, ялангуяа өвчин, хүүхдийн өсөлт хөгжлийн эмгэг тулгамдсан асуудал нь болоод байгаа хөдөө орон нутагт нийгмийн эрүүл мэндийн чухал сорилт хэвээр байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчны эрүүл мэндийн үндсэн стандартыг хэрэгжүүлэх зорилгоор ДЭМБ-аас хөдөө орон нутагт онцгой анхааран ус, эрүүл ахуй, эрүүл мэндийн

байгууллагын нөхцөлийг сайжруулахын тулд Эрүүл Мэндийн Яамтай нягт уялдаа холбоотой ажилласаар ирлээ. Энэ санаачилгын хүрээнд Монголын хөдөө орон нутгийн 260 суманд усны чанар, эрүүл ахуй, ариун цэврийн байдлыг үнэлэх судалгаа явуулахад 75 гаруй хувь нь дээрх шаардлагыг хангахгүй байгаа нь тодорхой болсон юм.

ДЭМБ-ын Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар, Эрүүл Мэндийн Яамны арга зүйн

туслалцаатайгаар Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын эмнэлэг усан хангамжаа сайжруулан улмаар эрүүл ахуйг чанд сахихад тулгарч буй энэ бэрхшээлийг шийдэх аргыг эрэлхийлжээ. Сумын захиргаа санаачилгыг гартаа авч эмнэлгийн ариун цэврийн нөхцөлийг сайжруулах, шинэ худаг гаргахад 2.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь орон нутгийн төрийн байгууллага нийгмийн эрүүл мэндийн асуудлыг шийдэхэд хэрхэн манлайлж болохыг харуулсан тод жишээ боллоо.

Жилд 600-800 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг тус эмнэлэг худаг гаргахад өмнө 900 метрийн холоос усаа зөөдөг байжээ. Тиймээс өдрийн хэрэгцээ нь ердөө 250 л усаар хязгаарлагддаг байсан бөгөөд ихэнхийг нь хоол хүнс бэлтгэх, цэвэрлэгээ хийхэд ашиглаж, ариун цэврийн үндсэн шаардлагыг хангахад үлдсэн ус нь хүрэлцдэггүй тул халдвараас хамгаалах асуудал бэрхшээлтэй байсан байна.

Эрүүл рашаан төслийн хүрээнд хоёр компани тус эмнэлэгт зориулан бохир ус зайлуулах төхөөрөмж дотор болон гадаа нь суурилуулжээ. Мөн бохир усны цистерн барих гэрээт ажлыг



*Зураг: Тасалгааны угаалтууртай Мөнххаан сумын эмнэлэгт ариун цэвэр сахина.*

ч гүйцэтгэсэн байна. Эмнэлгийн бүх тасагт орчин үеийн жорлон, угаалтуур суурилуулснаар өвчтөнүүд өвлийн хүйтэнд шөнө гадаа гарч бие засдаг байсан тэр үе ард хоцорчээ.

Түүнээс гадна эмнэлгийн баруун талд 60 метр гүн худаг гаргасан бөгөөд ундаргыг нь бохирдохоос сэргийлж 50 метр радиустай хашлага хийсэн байна. Ингэснээр энэ эмнэлэг 800 л багтаамжтай, бохирдохоос сэргийлсэн хуванцар тагтай торхноос ундны усаа авах боломжтой болсон юм.

Сумын эрүүл мэндийн байгууллагуудын ус, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл байдлыг сайжруулах нь Монгол Улсад нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалах үйлст хувь нэмрээ оруулах нь дамжиггүй. Усан хангамж муугаас мөн бохир нөхцөлөөс үүдсэн өвчлөлийг бууруулахаас гадна орон нутагт хэрэгжүүлсэн энэ мэт төсөл нь бусад сумдад ариун цэвэр, эрүүл ахуйг сайжруулах үлгэр дуурайл болж байна.

Санаачилгатай, тэмүүлэлтэй орон нутгийн удирдлага улс орон даяар өөрчлөлт хийх гол хүчин болж чадах нь тодорхой юм.



*Эрүүл рашаан төслийн хүрээнд эрүүл ахуйн сайжруулсан байгууламж барьж шинэ худаг гаргав.*

### Хүснэгт 1 (ДЭМБ-ын вэб сайтаас): Монгол улс

Үзүүлэлт	Хувь (он)
Ундны усны сайжруулсан, байнгын эх үүсвэртэй орон нутгийн хүн ам	48 (2006)
Ундны усны сайжруулсан, байнгын эх үүсвэртэй хотын хүн ам	90 (2006)
Эрүүл ахуйн сайжруулсан байгууламжтай орон нутгийн хүн ам	31 (2006)
Эрүүл ахуйн сайжруулсан байгууламжтай хотын хүн ам	64 (2006)

## ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ 10 БАРИМТ


1. Дэлхий даяар ойролцоогоор 2.6 тэрбум хүн эрүүл ахуйн зохих байгууламж ашиглах боломжгүй байна. Сахарын Африк (37%), Өмнөд Ази (38%), Зүүн Ази (45%) нь хамгийн доогуур хамралттай бүс нутгууд юм. Олон оронд энэ сорилтыг хурцатгаж буй шалтгаан нь дэд бүтэц мүү, нөхцөл байдлыг сайжруулах хөрөнгө хомс зэрэг юм.
2. Ариун цэврийн байгууламж байхгүй байх нь хүмүүсийг ил задгай газар, гол горхи болон хүүхэд тоглодог эсвэл хоол хүнс бэлтгэдэг газрын ойр бие засахад хүргэдэг. Энэ нь өвчин тараах эрсдлийг нэмэгдүүлдэг.
3. Хүний ялгадсаар бохирдсон усаар дамжин халдварладаг өвчинд суулгалт, булчин задрах тахал, цусан суулга, гэдэсний хижиг, гепатит А зэрэг багтана.
4. Эрүүл мэндийн байгууллагууд эрүүл ахуйн зохистой нөхцөлийг хангах шаардлагатай бөгөөд халдвараас хамгаалахын тулд ариун цэврийг чанд сахих ёстой. Дэлхийн жишгээс харахад эмнэлэгт хэвтэж буй өвчтөнүүдийн 5-30 хувь нь зайлсхийх бүрэн бололцоотой нэг болон түүнээс олон тооны халдварыг авсан байгаа нь ажиглагддаг.
5. Жил бүр 200 сая гаруй хүн ган, үер, халуун орны шуурга, газар хөдлөлт, ойн түймэр болон бусад гамшигт нэрвэгддэг. Осол гамшигийн хариу арга хэмжээ, нөхөн сэргээх хүчин чармайлтад эрүүл ахуйн байдлаас шалтгаалах өвчний тархалтыг зогсоох, хүн амд үндсэн үйлчилгээ үзүүлэх, өдөр тутмын жирийн үйл ажиллагаагаа явуулахад хүмүүст туслах нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм.
6. Эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах нь суулгалт өвчнөөр нас барах явдлыг гуравны нэгээр бууруулдаг болохыг судалгаа харуулж байна. Суулгалт өвчин нь үхэлд хүргэдэг томоохон шалтгаан болдог ч урьдчилан сэргийлэх боломжтой билээ. Энэ өвчнөөр жил бүр 1.5 сая хүн буюу хөгжиж буй орнуудад ихэвчлэн 5-аас доош насны хүүхдүүдийн аминд хүрдэг юм.
7. Эрүүл ахуйн зохистой нөхцөл хүүхдийг ялангуяа охидыг сургуульдаа явахад нь урам зориг өгдөг. Нийтийн жорлонтой байх нь хичээлийн ирцийг нэмэгдүүлдэг. Охидын элсэлтийн тоо нэмэгдэхийг ариун цэврийн нөхцөлийг бүрэн хангасантай холбон үзэж болно.
8. Ариун цэврийн боловсрол, гараа угаахын ач холбогдлыг сурталчлан таниулах нь суулгалт өвчний тохиолдлыг 45 хүртэл хувиар багасгаж болох энгийн бөгөөд үр дүнтэй арга юм. Зохистой хэмжээнд эрүүл ахуйн нөхцөл хангагдаагүй байсан ч хүн амын дунд ариун цэврийн дадал зуршлыг хэвшүүлж чадсан бол эрүүл байхад ач тусаа өгнө. Өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зохистой ариун цэвэр нь сайжруулсан байгууламж ашиглахтай нягт холбоотой.
9. Эрүүл ахуйн эдийн засгийн үр өгөөж нь гайхамшигтай. Эрүүл ахуйн байдлыг сайжруулахад зарцуулсан нэг ам.доллар тутамд дунджаар есөн ам.долларын өгөөж ирдэг. Эдгээр үр өгөөж нь ялангуяа ядуу буурай иргэд, хүүхэд багачуудад ирдэг байна.
10. Мянганы Хөгжлийн зорилтын дагуу 2015 он гэхэд дэлхий нийтийн эрүүл ахуйн хамрах хүрээг 75 хувьд хүргэхээр зорьж байна. Энэ зорилтод хүрэхэд жил бүр 14 тэрбум ам.доллар шаардагдана хэмээн тооцоолж байна. Эрүүл мэндийн салбар дахь олон үр ашгийн дундаас эрүүл ахуйн асуудалд анхаарал хандуулснаар дэлхийн хэмжээнд суулгалт өвчний тохиолдлыг жил бүр 391 саяар бууруулна гэсэн тооцоо бий.

*Эх сурвалж: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага*


# ШИНЭ НОМ - NEW PUBLICATIONS



Human Development Report 2007/2008  
Fighting climate change: Human solidarity in a divided world



Mongolian Human Development Report 2007  
Employment and poverty in Mongolia  
Монголын Хүний Хөгжлийн Илтгэл 2007  
Хөдөлмөр эрхлэлт, ядуурал



The Millennium Development Goals Implementation  
Second national report  
Мянганы Хөгжлийн Зорилтуудын Хэрэгжилт  
Үндэсний хоёр дахь илтгэл




New Horizons  
December-2008  
Шинэ Мэдээ  
2008 оны 12 сар



UNDP Pamphlet




The state of the world's children 2008  
Child Survival




State of world population 2008  
Reaching Common Ground: Culture, Gender and Human Right




Universal Declaration of Human Rights  
- Dignity and Justice for all of us  
Хүний эрхийн түүгээмэл тунхаглал  
- Нэр төр, шударга ёсыг хүн бүрт



New Horizons  
June-2008  
Шинэ Мэдээ  
2008 оны 6 сар




State of the World's Children 2009  
Maternal and Newborn health  
Дэлхийн хүүхдийн байдал 2009  
Эх, Нялхсын эрүүл мэнд




State of the World Population 2007  
Unleashing the Potential of Urban Growth  
Дэлхийн хүн амын байдал 2007  
Хотжилтын нөөц боломжийг ашиглах нь



United Nations Population Fund in Mongolia  
Helping build a better future



UNDP in Mongolia  
A better life for everyone  
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр Монголд  
Хүн бүрийн сайхан амьдралын төлөө



Children and Women in Mongolia  
• Current situation  
• Future goals  
Монгол улсын хүүхэд, эмэгтэчүүд  
• Өнөөгийн байдал  
• Ирээдүйн зорилтууд



Comprehensive Review of the National Response to HIV and STIs in Mongolia  
October 2008  
ХДХВ, ДОХ, БЗДХ-ын эсрэг үндэсний хариу арга хэмжээний хөндлөнгийн цогц үнэлгээ  
Аравдугаар сар 2008

and more / болон бусад